



# 2023-2024 ОНЫ ЗУДААС НИЙГЭМ ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ: ЗУДЫН ГАМШГИЙГ ДАВАН ТУУЛАХ СТРАТЕГИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

ХУРААНГУЙ

ХАМТРАН АЖИЛЛАСАН:



2025



Зургийн эх үүсвэр: НҮБХХ

Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй, тэр дундаа цаг агаарын гаралтай эрс тэс үзэгдэл болох зудын гамшгийн улмаас томоохон сорилт бэрхшээлтэй тулгарч байна. Тухайлбал 2023-2024 оны зудын уршгаар малчин өрхүүд малын хорогдол, эдийн засгийн хохирол ихээхэн амссан. Энэхүү тайлан нь зудын нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, хариу арга хэмжээг үнэлэхийн зэрэгцээ гамшгийн бэлэн байдал, даван туулах механизмд дутагдаж буй орон зайг илрүүлэх зорилготой юм. Мөн Монгол Улсын уур амьсгалын нөхцөл, гамшгийн эрсдлийн талаарх нарийвчилсан дүн шинжилгээ, өнөөгийн хууль эрх зүй, бодлогын орчин, эрт сэрэмжлүүлэх

системийг сайжруулах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг чиглэлээр гамшгийн эрсдэл, хүндрэл бэрхшээлийг урт хугацаанд даван туулах чадавхыг нэмэгдүүлэх зөвлөмжийг тус тайлангаар санал болгож байна. 2023-2024 оны өвлийн улиралд зудын гамшгийн улмаас нийт малын хэмжээ ойролцоогоор 12.5% хувиар хорогдсон нь малчдын амьжиргаа, хүнсний аюулгүй байдалд ихээхэн нөлөөлсөн. Олон улсын тусламж, дотоодын дэмжлэг үзүүлж байгаа хэдий ч дасан зохицох чадавхыг нэмэгдүүлэх, нийгэм-эдийн засгийн эмзэг байдлыг арилгах цогц стратеги шаардлагатай хэвээр байна.

## ■ Судалгаанд туссан үндсэн санаа

- Уур амьсгалын өөрчлөлт, ялангуяа зудын улмаас Монгол Улс нийгэм, эдийн засгийн томоохон сорилтуудтай тулгарч байна. Мал ихээр хорогдож малчдын орлого буурсанаас улбаалан 2024 оны эхний хагас жилийн байдлаар тус салбарын ДНБ-д оруулах хувь нэмэр 27 хувиар буурахад нөлөөлсөн.
- Төмөр зудын улмаас Сүхбаатар, Дорноговь, Говьсүмбэр, Хэнтий аймгуудад малын хорогдол ихэссэн.
- Амьжиргаа, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллөөс гадна гамшигт нэрвэгдсэн малчдын бие бялдар, сэтгэцийн эрүүл мэндийн асуудал, малчин өрхийн хүүхдүүд сургууль завсардах, зам тээврийн холбогдолтой бэрхшээл сорилт тулгарах, хот руу шилжилт хөдөлгөөн нэмэгдэх, гамшигт өртсөн өрхүүдэд жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ) ихсэх зэрэг нийгэмд үзүүлэх нөлөөлөл үлэмж хэмжээнд байгааг тус нийгэм, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээгээр-ээр тогтоов.
- Тус НЭЗНУ-ын тайлангаар нөлөөллийн үнэлгээг хийгээд зогсохгүй гадна хээрийн судалгаа хийж асуумж бөглүүлэх, гол оролцогч талуудтай х байдлаар гамшгийн эрсдэлийг үр дүнтэй бууруулах, уур амьсгалд дасан зохицох, дасан зохицох, даван тэсвэрлэх чадавхыг бий болгох механизмд зориулсан бодлогын зөвлөмжийг тодорхойлсон.
- Хэдийгээр хээрийн судалгаагаар бог мал малладаг малчид маш эмзэг байгааг харуулсан ч бог мал малладаг малчид малаа амжилттай аварч чадсан жишээ бий. Энэ нь малын тоо толгойг цөөлөх, өвс, тэжээлийг хангалттай нөөцлөх, зохих загвар бүхий хашаа хороо, чадавхаа зохих хэмжээнд бүрдүүлэх зэргээр зудын бэлэн байдлыг хангасантай холбоотой байж болох юм.
- Эрт сэрэмжлүүлэх тогтолцоо (EWS) болон олон нийтэд түшиглэсэн гамшгийн менежмент нь ирээдүйд нүүрлэж болох уур амьсгалаас үүдэлтэй цаг агаарын хүнд нөхцөл байдлын нөлөөллийг бууруулахад нэн чухал юм.
- Улсын хэмжээнд урьдчилан таамаглах, сэрэмжлүүлэх механизмд ахиц дэвшил гарч, малчид эрт сэрэмжлүүлэг авч байна. Гэсэн хэдий ч 2023-2024 онд нүүрлэсэн зудын жишээнээс үзвэл орон нутгийн түвшинд хариу арга хэмжээ авах чадамж хязгаарлагдмал байна. Бэлчээрийн хүртээмжгүй байдал, бэлтгэгдсэн хүний нөөц, техник хэрэгслийн хомсдол зэрэг нь орон нутгийн түвшинд тулгамдаж буй гол асуудал гэж тэмдэглэсэн.
- Монгол Улсад интернетийн хүртээмж, ухаалаг утасны хэрэглээ маш өндөр байгаа тул урьдчилан мэдээлэх, урьдчилан сэрэмжлүүлэх болон хохирлын үнэлгээний технологид суурилсан шийдлүүдийг оновчтой болгох шаардлагатай байна.
- НҮБ-ын Монгол улс дахь Хүмүүнлэгийн баг, түүний зохион байгуулалт үйл ажиллагаагаар дамжуулан Засгийн газар, хүмүүнлэгийн болон хөгжлийн түншүүд зудын үед нягт уялдаатай ажиллаж, хариу арга хэмжээ авах механизмтай байх нь үр дүнтэй болох нь ажиглагдсан. Механизмын хүрээнд хамтын оролцоог дайчлах замаар зудын гамшгийн үеийн хариу арга хэмжээг авсан хэдий ч 8.1 сая мал хорогдсон нь маш өндөр дүн юм.
- Нөлөөллийн тооцоолол хийх ажил аль хэдийн хийгдэж байгаа хэдий ч гамшгийн өмнө малчин өрхүүдэд тулгарч буй санхүүгийн хүндрэлийг шийдвэрлэх, малын хорогдол, түүнээс үүдэлтэй нийгэм, эдийн

- засгийн нөлөөллийг бууруулахын тулд Урьдчилан таамаглалд суурилсан санхүүжилтээр нөхөх шаардлагатай байна.
- 2017 онд Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсны дараа нийт 21 аймагт гамшгийн эрсдэлийг бууруулах төсвийг 4.5 дахин (2018 онд 2,3 тэрбум төгрөг байсан хэмжээг 2022 онд 10.4 тэрбум хүртэл нэмэгдүүлсэн) төсөвлөсөн. 2015-2022 оны хооронд гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийг бууруулахтай холбоотой төсвийг тухайн гамшгийн хүндрэл, эрчмээс хамааруулан зарцуулсан.
- Засгийн газраас гаргасан Шинэ хоршоо санаачилгыг малчид талархалтайгаар хүлээн авч буй боловч энэ санаачилга дөнгөж эхлэлийн шатанд байгаа, малчдад зээл олгох үйл явц нарийн төвөгтэй байх, барьцаа хөрөнгөтэй холбоотой асуудлуудыг ойлгох боловсрол, нөлөөлөл сурталчилгааны мэдээлэл дутмагаас шалтгаалан төдийлөн ашиг хүртэж эхлээгүй байна.
- Даатгалын гэрээгээр хариуцах эрсдэлийн нийт дүн 10 хувиас бага байгаа нь тогтоогдсон. Бог мал маллаж буй малчдад ашигтай байх үүднээс параметрийн даатгалын механизмд өөрчлөлт оруулах шаардлагатай байна.
- Зудын нөлөөллийн үнэлгээ нь гол төлөв малын хорогдлын нөлөөллийг үнэлэхэд чиглэдэг. Гамшгийн дараах нөлөөллийн цогц үнэлгээ, сэргээн босгох хэрэгцээний үнэлгээг улс болон аймгийн түвшинд даван туулах иж бүрэн стратегид тохируулан боловсруулж, ирээдүйн хөгжлийн төлөвлөгөөнд даван туулах чадавхыг бүтэц зохион байгуулалтын орчинд нэвтрүүлэх шаардлагатай.
- 2024 оны зудын дараах нөхөн сэргээлтийг мал аж ахуйн менежментийг сайжруулах, малын ашиг шимийг байгаль орчинд ээлтэй байдлаар нэмэгдүүлэх, зөвхөн мал маллахын оронд сүү, сүүн бүтээгдэхүүн, мах, арьс ширнээс илүү орлого олох боломж болгон ашиглах.
- НЭЗНҮ-ний судалгаа, гол оролцогч талууд болох Засгийн газар, НҮБ-ын агентлагууд, ОУУЗН болон МУЗН, ТББ, олон улсын ТББ-ууд, багийн түвшинд сонгогдсон нийтийн хурлын төлөөлөгчид, түүнчлэн гамшигт өртсөн малчин өрхүүдтэй хийсэн уулзалт, ярилцлагуудад үндэслэн зудын гамшгийг даван туулах чадавхыг хөгжүүлэх стратегийн бодлогын зөвлөмжийг боловсруулав. Тус зөвлөмжид богино болон урт хугацааны бодлогын арга хэмжээ цогц байдлаар тусав.



Зургийн эх үүсвэр: НҮБХХ

## ■ Богино хугацааны зөвлөмжүүд



### 1. Нөлөөлөлд суурилсан урьдчилан таамаглах болон эрт сэрэмжлүүлэх сайжруулсан тогтолцоо (EWS)

Янз бүрийн хэрэглэгчдэд тохирсон урьдчилан мэдээлэх, урьдчилан сэрэмжлүүлэх системийг бий болгож, хэрэгжүүлэх, түүнийг үр дүнтэйгээр иргэд олон нийтэд ашиглуулахад чиглэсэн таниулах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, зохион байгуулах.



### 2. Нөлөөлөлд суурилсан санхүүжилт:

Яаралтай тусламж үзүүлэх болон зайлшгүй шаардлагатай хангамжид зориулж нөөцийг хуваарилах. Урьдчилан таамаглалд үндэслэн яаралтай тусламжийн санхүүжилт олгох, санхүүгийн тусламж үзүүлэх. Гамшгийн үед малын даатгалын нөхөн төлбөр олгох явцыг түргэсгэх.



### 3. Хариу арга хэмжээ авах механизм, түүний чадавх:

Онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах чадавхыг сайжруулж, зайлшгүй шаардлагатай зүйлсийг тасралтгүй нийлүүлж, малчдад зориулсан бүх улиралд үйлчлэх явуулын үйлчилгээг нэмэгдүүлнэ.



### 4. Технологийн шийдэл:

Шуурхай үнэлгээ, хариу арга хэмжээг хянах технологи ашиглах, цаг агаарын ажиглалтын сүлжээг өргөжүүлэх, хямралын зураглалд сошиал медиа краудсорсинг ашиглах. Цаашлаад малчин өрхүүдэд зориулсан онлайн сургалтын платформыг нэвтрүүлж, хөдөө орон нутагт цахим худалдааны платформоор дамжуулан зах зээлийн боломжийг нэмэгдүүлэх боломжийг өргөтгөх.



### 5. Эрүүл мэнд, сэтгэл зүйн дэмжлэг:

Эмзэг бүлгийн хүмүүсийн хоолтэжээл, эмнэлгийн тусламж үйлчилгээг хангах, гамшгийн үед жендэрт суурилсан хүчирхийллийн талаар зааварчилгаа өгөх, сэтгэцийн эрүүл мэндийн дэмжлэг, зөвлөгөө өгөх. Алслагдсан бүс нутгийн хүн амын хувьд мал эмнэлгийн үйлчилгээ, түүнчлэн гамшигт өртсөн өрхийн гишүүдийн биеийн эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ нь эрсдэлийн нөхцөл байдал орж буй өөрчлөлт, түүнтэй уялдуулан тухайн үүссэн нөхцөл байдлыг хүлээн авч даван туулах, дасан зохицох арга хэмжээг ойлгоход нь малчдад туслах оновчтой шийдэл байж болох юм.

## ■ Урт хугацааны зөвлөмжүүд



### 1. Мал аж ахуйн менежментийг сайжруулах:

Мал аж ахуйн чиглэлээрх сургалт, зөвлөх үйлчилгээнд хөрөнгө оруулалт хийж, малчдын чадавхыг дээшлүүлж, даван туулахад чиглэсэн урт хугацааны мал аж ахуйн тогтвортой менежментийн туршлагыг хэрэгжүүлэх.



### 2. Хөдөө, орон нутгийн дэд бүтцийг сайжруулах:

Зам, харилцаа холбооны сүлжээ, малын өртгийн сүлжээ, мал эмнэлгийн төвүүдэд хөрөнгө оруулалт хийх. Хөдөөгөөс хот руу шилжих хөдөлгөөнийг бууруулахын тулд малчдын нийгэм, эдийн засгийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах.



### 3. Уур амьсгалд дасан зохицох ба эрсдэлийн менежмент:

Судалгаа, уур амьсгалд дасан зохицох туршлагыг нэвтрүүлэх, стратегийн нөөцийн хуваарилалтаар дамжуулан даван туулах чадавхыг нэмэгдүүлнэ.



### 4. Бэлчээрийн менежмент:

Эрсдэлийн үнэлгээ хийж, бэлчээрийн нөхцөл байдалд хяналт тавьж, газрын тогтвортой менежментийг хэрэгжүүлнэ.



### 5. Олон нийтэд суурилсан урт хугацааны төлөвлөлт:

Төлөвлөлт, хариу арга хэмжээний стратегид олон нийтийг сургаж, татан оролцуулах.



### 6. Эдийн засгийг солонгоруулах:

Мал аж ахуйгаас хараат байдлыг бууруулахын тулд хөдөө, орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэл (ЖДҮ)-ийг багтаасан газрын нэгдсэн менежмент, сэргээгдэх эрчим хүч, амьжиргаа залгуулах бусад хувилбаруудыг санал болгосон хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулах. Алслагдсан бүс нутагт байгаа малчдын хоршоо, ЖДҮ-үүдэд зориулан цахим худалдааны шийдэл нэвтрүүлэх.



### 7. Санхүүгийн заалтууд:

Гамшгийн эрсдэлийн санхүүжилтийн үндэсний стратеги, уур амьсгалын санхүүжилтийн механизмыг боловсруулах. Уур амьсгалын чиглэлээрх ногоон зээл, параметрт суурилсан цаг агаарын даатгалын бодлогыг нэвтрүүлэх.

Үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэхэд хууль эрх зүй, бодлогын тогтолцоонд өөрчлөлт оруулах нь орон нутгийн түвшинд нэн чухал боловч үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд олон улсын дэмжлэг зайлшгүй шаардлагатай. Гамшгийн нөлөөлөл өргөн цар хүрээтэй байгаа тул зудын нөлөөг бууруулахын тулд малчдын дасан зохицох чадвар, даван туулах чадавхыг нэмэгдүүлэх нь чухал юм.

Мөн гамшгийн үед газар зүйн байршлын хувьд тусламж үзүүлэхэд бэрхшээлтэй, нөөцийн хүрэлцээ хязгаарлагдмал зэргээс шалтгаалж орон нутгийн удирдлагууд малчдад хангалттай хэмжээнд хөрөнгө, техник хэрэгслийн дэмжлэг олгож ажиллахад хүндрэлтэй байна. Тиймээс ирээдүйд их хэмжээний гарз гарахаас зайлсхийхийн тулд урт хугацааны даван туулах, дасан зохицох чадамжийг бий болгох шаардлагатай байна.

